



ОЮУТНЫ СТАТУС/БАЙДАЛ – ОЮУТАН/СУРАГЧ гэж хэн бэ?

ОЮУТАН (сурагч, дагалдан суралцагч, сонсогч) - ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн дээд сургууль, их дээд сургуульд суралцдаг оюутан (бүх насны).

ОЮУТНЫ БАЙДАЛ – энэ нь албан ёсны нэр томъёо биш юм. Сургуульд сурдаг улмаас тодорхой давуу талтай оюутнууд юм.

ОЮУТНЫ ДАВУУ ТАЛУУД - та бүтэн цагаар/өдрөөр суралцаж байхдаа авах болно!

- **26 нас хүртлээ улсаас нийгмийн эрүүл мэндийн даатгал** (докторын сургалтад 28 нас хүртэл) төлнө.
- **Татварын хөнгөлөлт** – 26 нас хүртэл орлогын албан татварын хөнгөлөлт, докторын сургалтад 28 нас хүртэл, 26 нас хүртэл хүүхдийн хөнгөлөлт.
- **Нийгмийн тэтгэмж** - 26 нас хүртэл.
- **Тасалбарын хөнгөлөлт** (26 нас хүртэл), унаа, соёл гм.
 - o ISIC карт – оюутны үнэмлэх (зурагтай), зарим сургуулиудад сургалтын өрөө, номын сан зэрэгт нэвтрэх карт болгон ашигладаг. Сургуулийн байрнаас гадуур энэ картыг музей, галерей, дурсгалт газруудаар зочлох гэх мэт давуу талтай. Та давуу талын тоймыг дараах цахим хуудаснаас www.isic.cz авах боломжтой.

Оюутны байдал хэзээ үүсдэг вэ? Бүтэн цагийн/өдрөөр сургалцахад зохих ёсоор бүртгүүлэх/дахин бүртгүүлэх замаар.

Оюутны байдал хэзээ дуусах вэ (сургуулийн үүднээс)?

- Төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн өдөр (ахлах сургууль төгсөх шалгалт/улсын төгсөлтийн шалгалтын сүүлийн хэсэг).
- Үргэлжлүүлэн суралцах нөхцөлийг хангаагүйн улмаас сургуулиа дуусгавар болгох (жишээлбэл, их сургуульд кредитийн тоо хангалтгүй) / сургуулиа орхисон тухай бичгээр мэдэгдэл / сургуулиас хөөгдсөн.
- Сургуулиас завсарлаг авах (та оюутны байдлаа алдсан ч дахин суралцах эрхтэй).

Дунд сургууль, ахлах сургуулийн хоорондох хугацаа - та зуны амралтаараа ч гэсэн оюутан. Харин ахлах сургуульд орохгүй, бол амралтын дараа оюутан байхаа болно.

Ахлах сургууль болон их дээд сургуулийн хоорондох хугацаа - хэрэв та зуны амралтын дараа их сургуульд элссэн, бол зуны амралтаараа ч гэсэн тасралтгүй оюутан байна (суралцах элсэлт бүртгүүлэх).

Ахлах сургуулийн дараах хэлний сургалт - хэрэв та бүтэн хичээлийн жилийн турш бүтэн цагаар суралцдаг, тухайн сургууль нь Боловсролын яамнаас магадлан итгэмжлэгдсэн ба алхах сургуулийн төгсөн шалгалт өгсний дараа хуанлингийн жилийн эцэс гэхэд суралцаж эхэлсэн бол та оюутан гэсэн үг.

Гадаадад суралцах - энэ нь аяллын төрлөөс хамаарна:

- Чехийн магадлан итгэмжлэл бүхий их сургуулийн оюутан хэвээр үлдвэл, та оюутны байдлаа алдахгүй.
- БНЧУ-д цуцалж, гадаадад сургуульдаа үргэлжлүүлэн суралцах тохиолдолд:
 - Боловсролын яамнаас тус сургуулийг Чех улсын их, дээд сургуульд тэгш эрхтэйгээр сургана гэж хүлээн зөвшөөрч - та оюутны байдлаа алдахгүй,
 - Боловсролын яамнаас сургуулийг хүлээн зөвшөөрөхгүй - та оюутны байдлаа алдана.



[Би сургуулиа төгссөн гэсэн ч оюутны байдлаа хадгалах уу?](#)



[Би их/дээд сургуулиа төгсөөд хэдий хүртэл оюутан байх вэ?](#)



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Poradna
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.